# ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 11 сарын 20 өдөр Дугаар 554 Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шинжлэх Ухааны Академийн Одон орон геофизикийн хүрээлэнгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон нийт 76,097,185.00 (далан зургаан сая ерэн долоон мянга нэг зуун наян таван) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баярсайхан, Шинжлэх Ухааны Академийн Одон орон геофизикийн хүрээлэнгийн захирал С.Дэмбэрэл нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэгээр худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА Б.ГАВАА

0002529

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн
554 дугаар тогтоолын хавсралт

Шинжлэх ухааны академийн Одон орон, геофизикийн хүрээлэнгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй актлаж, данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

| Д/д | Хөрөнгийн нэр, марк | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Ашиглалтад орсон огноо | Балансын | | Хуримтлагдсан элэгдэл | Үлдэгдэл өртөг | Автомашиныг актлаж, элбэгээр худалдсанаас олох орлогын доод хэмжээ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ | | | |
| | | | | | (Төгрөг) | | | | |
| 1. Барилга байгууламж | | | | | | | | | |
| 1.1 | Соронзонгийн Абсолют павильон | ш | 1 | 1966.01.01 | 7,987,000.00 | 7,987,000.00 | 7,987,000.00 | - | |
| | **Бүгд дүн** | | **1** | | **7,987,000.00** | **7,987,000.00** | **7,987,000.00** | **-** | |
| 2. Авто тээврийн хэрэгсэл | | | | | | | | | |
| 2.1 | Тоёото Карина, УБГ 86-35, суудлын автомашин | ш | 1 | 2001.01.01 | 10,067,085.00 | 10,067,085.00 | 10,067,085.00 | - | 200,000.00 |
| 2.2 | Мазда ӨМА 81-79, суудлын авто машин | ш | 1 | 2001.01.10 | 5,500,000.00 | 5,500,000.00 | 5,500,000.00 | - | 200,000.00 |
| 2.3 | УАЗ 22069 БӨА 94-46, суудлын автомашин | ш | 1 | 2001.01.11 | 6,512,400.00 | 6,512,400.00 | 6,512,400.00 | - | 300,000.00 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.4 | УАЗ 469, УБМ 84-47, суудлын автомашин | ш | 1 | 2004.01.01 | 15,403,500.00 | 15,403,500.00 | 15,403,500.00 | - | 300,000.00 |
| 2.5 | УАЗ 31519, УБМ 84-95, суудлын автомашин | | 1 | 2004.01.01 | 15,403,500.00 | 15,403,500.00 | 15,403,500.00 | | 300,000.00 |
| 2.6 | УАЗ-22069, ӨМА 67-93, машин | ш | 1 | 2007.01.01 | 14,673,700.00 | 14,673,700.00 | 14,673,700.00 | - | 300,000.00 |
| **Бүгд дүн** | | | **6** | | **67,560,185.00** | **67,560,185.00** | **67,560,185.00** | **-** | **1,600,000.00** |
| 3. Програм хангамж | | | | | | | | | |
| 3.1 | ХО - Програмын үнэ | ш | 1 | 2014.02.24 | 550,000.00 | 550,000.00 | 550,000.00 | - | |
| **Бүгд дүн** | | | **1** | | **550,000.00** | **550,000.00** | **550,000.00** | **-** | |
| **Нийт дүн** | | | **60** | | | **76,097,185.00** | **76,097,185.00** | **-** | **1,600,000.00** |
| | | | | | | **(далан зургаан сая ерэн долоон мянга нэг зуун наян таван)** | | | **(нэг сая зургаан зуун мянган)** |